



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН
ТУШААЛ**

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 4/40

Дэлгэрхаан сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ариутгалын хэсгийн журмыг нэгдүгээр, Ариутгалын хэсгийн тусламж үйлчилгээний багжийн жагсаалтыг хоёрдугаар, Жижиг мэс ажилбар, төрөх, эмэгтэйчүүдийн хэрэгслийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг ариутгагч (С.Баярцэцэг)-т даалгасугай.

ЭРХЛЭГЧ



О.БАТБАЯР



Ариутгалын хэсгийн журам

- 1.Багаж хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, ариутгах үйл ажиллагааг гүйцэтгэхдээ багаж ,хэрэгслийн хэрэглэх зориулалт, материалын халуун тэсвэрлэх чанар, хэлбэр хэмжээ, бохирдолтын байдал, нянгийн гадна орчинд тэсвэрлэх чадвар зэргийг харгалзан улсын бүртгэлд бүртгэгдсэн химийн бодисуудыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.
- 2.Тасаг нэгжүүдээс багаж хэргслүүдийг хүлээж авах ,түгээх цагийн хуваарьтай байна. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд цагийн хуваарийг харгалзахгүй.
- 3.Ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт ,ажиллах зааврыг байрлуулсан техник ашиглалтын дэвтрийг байнга хөтөлнө.
- 4.Ариутгах үйл явцын аль нэг хэсэгт гэмтэл гарсан тохиолдолд тухайн гэмтсэн аппаратаар ариутгасан бүх багаж, материалыг хүлээн авсан тасар, нэгжүүдээс нь эргүүлэн татаж, дахин ариутгана.
- 5.Ариутгалын хэсэгт ажиллах ажилтан нь вируст гепатит В-ийн дархлаажуулалтад хамрагдаж, жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.
- 6.Ариутгалын хэсэгт ажиллах эмнэлгийн мэргэжилтэн нь халдварын сэргийлэлт хяналт, халдваргүйтгэл, ариутгалын чиглэлээр сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй байна.
- 7.Ариутгал халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллана.
- 8.Ариутгалын хэсэгт ажиллах ажилтан нь халад буюу өмд цамц, малгай ,амны хаалт, гутал зэргийг хэрэглэнэ.
- 9.Ариутгалын хэсгийн бохир хэсэгт ажиллах ажилтан нь ус нэвтэрдэггүй халад, хормогч ,ханцуйвчийг нэмэлтээр өмсөнө. Бохир хэсэгт ажилласан хувцастай бусад өрөөгөөр сэлгүүцэхийг хориглоно. Бохир хэсгээс гарахад хамгаалах хувцас хэрэгслийг зааврын дагуу тайлж ,гарыг эрүүл ахуйг сахина.
- 10.Эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн багаж хэрэгслээс цус уургийн үлдэгдэл шалгах тестээр сар бүр хяналт хийнэ.
- 11.Эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн багаж болон материалуудад гадна болон дотор индикаторыг байнга тавьж хянаж ажиллах.
- 12.Автоклавын уурын тархалт болон биологийн индикаторыг сард 1 удаа тавьж хяналтыг тогтмол хийж тэмдэглэл хийж зурагжуулан ажиллах.
- 13.Ариутгалд хөтлөгдөх анхан шатны маягтуудыг үнэн зөв байнга хөтөлж ажиллах.
- 14.Багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт , ариутгалын үйл ажиллагааг үнэлэх дотоод хяналтын хуудсаар жилд 2 удаа үнэлж шалгаж байх

Эрхлэгчийн... 2012 оны 12 сарын 28 өдрийн
 А/х.о. тоот тушаалын... хавсралт

Жижиг мэс ажилбар, төрөх, эмэгтэйчүүдийн багаж хэрэгслийн багц

№	Багаж хэрэгслийн нэр	Багц	Тоо ширхэг	Тайлбар
1	Хөвөн шаарик	1	30ш	
2	Бинт шаарик	1	10ш	
3	Зүү баригч	1	1	
4	Зажем		1	
5	Пенцепт		1	
6	Хайч		1	
7	Зажем	1	1	
8	Пенцепт		1	
9	Зажем	1	1	Хүйн багж
10	Зүү баригч		1	
11	Хайч		1	
12	Өргөгч толь	1	1	Умай хүзүү шалгах
13	Дарагч толь		1	
14	Цонхот хавчаар		2	
15	Хайч	1	1	Ерөндөг тавих багж
16	Умай хүзүү баригч		1	
17	Зоонд		1	
18	Зажим		1	